

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАН

Сэдэв: Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл

2025 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс гаргасан өргөдлийг /цаашид “нийтийн өргөдөл” гэх/ цахим системээр хүлээн авч болно.” гэж, мөн зүйлийн 39.2-т “Нийтийн өргөдлийг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 болон 8-д заасан Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд гаргана.” гэж заасан.

Энэ хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр иргэн Батбаатарын Мөнгөнхишиг нийтийн өргөдөл, гомдлын систем petition.parliament.mn цахим хуудсанд Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” болон бусад холбогдох үйл ажиллагааны төсөв, гүйцэтгэл, үүний ил тод байдалд үнэлгээ хийж, цаашид хэрэгжих төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг сайжруулахыг шаардаж “Утааны сонсгол хийцгээе! Төсвийн зарцуулалтад хяналт, үнэлгээ хийж, сайжруулцгаая!” сэдэвт өргөдлийг үүсгэн, иргэдээс гарын үсэг цуглуулж эхэлсэн бөгөөд энэхүү өргөдөлд 71,452 иргэн гарын үсэг зурсан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т заасны дагуу 70,000 ба түүнээс дээш тооны иргэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах саналыг дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7 дугаар тогтоолоор агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.

Тус ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар, Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар, Хүний эрхийн дэд хорооны дарга Сүхбаатарын Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал, Цэндийн Баатархүү, Пүрэвийн Батчимэг, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Амгаланбаатарын Ганбаатар, Гомбын Ганбаатар, Мөнгөнцогийн Ганхүлэг, Сонгобайн Замира, Жаргалсайханы Золжаргал, Сүрэнжавын Лүндэг, Мэндбаярын Мандхай, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Загджавын Мэндсайхан, Бадрахын Найдалаа, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Отгоны Саранчулуун нар ажиллалаа.

Түүнчлэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 8 дугаар тогтоолоор агаарын бохирдол, утааны асуудлаар зохион байгуулах ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнг томилж, 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хуралдаж, асуудлын цар хүрээ, ажиллах боломжийг харгалзан, Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан журмыг баримтлан Ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдөр “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр зохион байгуулахаар тогтож, тус Байнгын хорооны 10 дугаар тогтоолыг баталсан.

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААР:

Ажлын хэсэг ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж, бэлтгэл ажлын хүрээнд дараах 4 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд эдгээр хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 194 иргэн, төрийн байгууллагын 93 албан тушаалтан оролцож, 75 иргэдийн төлөөлөл холбогдох төрийн байгууллагаас асуулт асууж, хариулт авч, 28 иргэн танилцуулга хийсэн байна. Үүнд:

1.2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Агаарын бохирдол-хүн амын эрүүл мэнд (Амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх) сэдвээр эхний хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд удирдан явууллаа.

Тус хэлэлцүүлэгт төрийн зарим байгууллагын холбогдох албан тушаалтнууд, салбарын эрдэмтэн судлаачид, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл зэрэг нийт 90 гаруй хүн оролцсон.

“Агаарын бохирдол-Хүн амын эрүүл мэнд” сэдвийн хүрээнд “Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, хянах, тандах чиглэлээр одоогийн авч хэрэгжүүлж буй бодлого, хэрэгжилтийн үр дүн, цаашдын төлөвлөгөө” сэдвээр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, “Монгол Улсын хот суурин газрын агаарын бохирдол, эх үүсвэр, тооллого, эх үүсвэрийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, цаашдын бодлого” сэдвээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, “Агаарын бохирдол: Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгаа” Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, “Монгол Улсад гадаад, дотоод орчны агаарын бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн чиглэлээр хийгдсэн судалгааны тойм” сэдвээр анагаах ухааны доктор, судлаач А.Энхжаргал, “Агаарын бохирдол жирэмсэн эх, урагт нөлөөлөх нь” сэдвээр Анагаахын шинжлэх ухааны Үндэсний их сургуулийн багш, доктор, дэд профессор, зөвлөх эмч Б.Жаргалсайхан, “Агаарын бохирдол хавдрын үүсгэгч болох нь” сэдвээр Хавдар судлалын Үндэсний төвийн Цээжний хөндийн мэс заслын тасгийн эрхлэгч Б.Ганзориг нар тус тус илтгэл танилцуулсан бөгөөд илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гадна оролцогч 16 иргэн асуулт асууж, хариулт авсан байна.

Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтийг товч авч үзвэл:

- 2023 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн В/2589 дугаартай Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталсан “Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага” MNS 5679:2022 стандартыг яаралтай шинэчлэх;
- Агаарын чанарын бүс рүү зөвшөөрөлгүй түүхий нүүрс оруулж байгаа эсэх, бүсэд зөвшөөрөлгүй түүхий нүүрс болон бусад зүйлс түлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж хэрэгжилтийг 7 хоног бүр тайлагнаж, шийдвэр гарч байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй байгаа;
- 2010 оноос хойш агаар болон орчны бохирдолд анхаарал хандуулж эхэлснээс хойш олон хөтөлбөр, төслийг хэрэгжүүлсэн хэдий ч эдгээр төсөл, хөтөлбөрийн

хамрах хүрээ хэт өргөн тусгагдсан, өртөг зардал өндөр, бодит үр дүнд хүрэх санхүүжилт, институцүүдийн чадавх, салбар хоорондын уялдаа муу хяналт хариуцлагын эргэх холбоо сул байсан. Цаашид бодлогын уялдаа, зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд холбогдох нарийн мэргэжлийн судлаач, эмч нарын төлөөллийн оролцоог хангасан, төр, бизнес, хувийн хэвшил, иргэд, судлаачдын багийг байгуулж ажиллах;

- Байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа 30 орчим хууль, 200 орчим эрх зүйн акт, норм ба дүрэм стандартын давхардал, зөрчил, хийдэл ихтэй байсан. Засгийн газраас 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг цаг хугацааны мөчлөгтэй, оновчтой, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, ач холбогдолтой шалгуураар үнэлэх шаардлагатай;
- Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ Улаанбаатар хотын гадаад, дотоод орчны агаар дахь PM10, PM 2.5-ын агууламжийг бууруулсан боловч хүн амын эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх хэмжээнд байсаар байна. Түүхий нүүрсний хэрэглээний үед өвлийн улирлын агаарын чанарын найрлага дахь PM 10, PM 2.5, CO, SO2 хэмжээ нэмэгдэхэд ураг аяндаа зулбалтын давтамж нэмэгдэж, үр хөврөл бүрэлдэх байдал буурах хандлага ажиглагдсан байна. Монгол Улсад агаарын бохирдлын эрсдэлт хүчин зүйлийн нөлөөгөөр уушгины хавдраас гадна элэгний хавдарт нөлөөлж хавдрын өвчлөл жилээс жилд тогтвортой нэмэгдэж байна. Олон улсад хийгдсэн судалгаагаар түүхий нүүрсний хэрэглээний улмаас уушгины хавдар өвчний тохиолдлыг нэмэгдүүлж байгааг тогтоосон.

2.2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр “Утааны асуудал: Стандарт , хяналт (Зуух, түлшний технологи)” сэдвээр хоёр дахь хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан удирдан явууллаа. Тус хэлэлцүүлэгт холбогдох төрийн зарим байгууллагын холбогдох албан тушаалтнууд, салбарын эрдэмтэн судлаачид, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий нийт 120 гаруй хүн оролцсон. Эдгээрээс төрийн байгууллагын 27, бусад байгууллагаас 10, иргэн, хуулийн этгээдийн 62 төлөөлөл оролцлоо.

Хэлэлцүүлэгт “Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх танилцуулга” сэдвээр Нийслэлийн засаг дарга Х.Нямбаатар, “Нүүрсний болон бусад цэвэр түлшний технологи хөгжүүлэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын бодлого” сэдвээр Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, “Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, технологи, чанар, стандарт, хяналт” сэдвээр “Таван толгой түлш” ХХК-ийн Ерөнхий технологич Д.Өлзийбат, “Агаарын бохирдол үүсгэгч эх үүсвэрүүдэд тавих хяналт” сэдвээр Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү, “Шахмал түлшний түүхий эд, шахмал түлшний шинж чанар, стандарт үзүүлэлт” сэдвээр ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн Нүүрсний хими техникийн лабораторийн эрхлэгч, техникийн ухааны доктор Г.Шийрав нар илтгэл танилцуулж, мэдээлэлтэй холбогдуулан 26 оролцогч иргэдийн төлөөлөл холбогдох албаны хүмүүсээс асуулт асууж, хариулт авсан.

Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтийг товч авч үзвэл:

- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас гаргасан 2022 оны тайланд гэр хорооллын 198,840 яндангаас гарч буй утаа агаарын бохирдлын 55.6 хувь, 804.656 автомашины утаа 28.9 хувь, дулааны цахилгаан станцын үнсэн сан зэрэг бусад үүсгүүр 15.5 хувийг эзэлж байна;

- Улаанбаатар хотын төвийн дүүргийн гэр хорооллын өрхийн тоо 2000 оноос 2022 он хүртэл 2,4 дахин нэмэгдсэн нь агаарын бохирдол нэмэгдэх үндсэн шалтгаан болсон;
- Цаг уур орчны шинжилгээний газрын 2023 онд хийсэн Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын бохирдлын эх үүсвэрийн судалгааны дүнгээр гэр хорооллын болон усан халаалтын зуух 80 хувь, авто тээврийн хэрэгсэл 10 хувь, дулааны цахилгаан станц 6 хувь, хог шороо, хөрсний бохирдол 4 хувьтай байна;
- Мидлинг болон хагас коксоор үйлдвэрлэсэн сайжруулсан түлшний техникийн үзүүлэлтүүдийг харьцуулахад дэгдэмхий 51.9, хүхэр 57.7, үнслэг 37.2 хувиар бага байгаа нь хагас коксон сайжруулсан түлшийг хэрэглээнд нэвтрүүлснээр агаарын чанарыг сайжруулахад шууд нөлөө үзүүлэх нь туршилтаар тодорхойлогдсон;
- түлшний горим алдагдаж дутуу шаталтын явцад угаарын хий, дэгдэмхий органик нэгдлүүд үүсэх эрсдэл гардаг. Сайжруулсан шахмал түлш хэрэглэснээр түүхий нүүрсний хэрэглээг 60%-аар бууруулж, илчлэгийг нэмэгдүүлж, хэрэглээг 54 хувиар бууруулснаар энэ хэмжээгээр агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан гэж үзэх боломжтой. Чийг болон дэгдэмхий хийн үзүүлэлтийг бууруулсан сайн талтай ч үнслэг болон хүхрийн хэмжээ нэмэгдсэн сөрөг үр дүн гарсан. Гэвч үүнийг нийт хэрэглэж байгаа түлшний хэмжээнд авч үзвэл түлшнээс ялгарч болох хүхрийн хэмжээ 3%-аар, үнслэгийн хэмжээ 19%-аар тус тус бууруулсан;
- цаашид түүхий эд, бүтээгдэхүүний стандартыг сайжруулах замаар түлшний чанарыг дээшлүүлэх, яндангийн тоо, түлшний хэрэглээг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай.

3.2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр “Утааны асуудал: Эрх зүйн орчин, бодлого шийдвэрийн хэрэгжилт, санхүүжилт, хариуцлага” сэдвээр гурав дахь хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар удирдан явууллаа.

Тус хэлэлцүүлэгт төрийн зарим байгууллагын холбогдох албан тушаалтнууд, салбарын эрдэмтэн судлаачид, иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий нийт 90 гаруй хүн оролцсон. Эдгээрээс төрийн байгууллагын 30, бусад байгууллагаас 13, иргэн, хуулийн этгээдийн 47 төлөөлөл оролцлоо.

Хэлэлцүүлэгт “Агаар, орчны бохирдолд зарцуулсан төсвийн сүүлийн 15 жилийн тойм” сэдвээр Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, “Агаарын бохирдлыг бууруулах асуудлаарх эрх зүйн орчин, төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” сэдвээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, “Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, санхүүжилт, үр дүн” сэдвээр Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, “Бодлого шийдвэр, санхүүжилт, зарцуулалт” сэдвээр “Тавантолгой түлш” ХХК-ийн Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Ариунзаяа нар тус тус илтгэл танилцуулсан бөгөөд Илтгэлтэй холбогдуулан хэлэлцүүлэгт оролцож буй 33 иргэн, Улсын Их Хурлын 5 гишүүн асуулт асууж, холбогдох албан тушаалтнуудаас хариулт авлаа.

Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтийг товч авч үзвэл:

- 2018 оноос эхлэн улсын төсвийн бодлогод агаарын бохирдол гэсэн тусгай арга хэмжээг үүсгэн хөрөнгө төсөвлөсөн. Агаар, орчны бохирдлыг бууруулах

үндэсний хөтөлбөр /2018-2025 он/, Монгол Улсын Засгийн газрын “Хөтөлбөр батлах тухай” 2017 оны 98 дугаар тогтоолын хүрээнд /2018-2024 он/ улсын төсвөөс нийт 336.1 тэрбум төгрөг төсөвлөж, үүнээс 276.3 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл нь 82.2 хувьтай байна. Улаанбаатар хотын Агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардал 243.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон;

- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2010 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, Цэвэр агаар санг байгуулсан бөгөөд энэ хүрээнд жилдээ 5-30 тэрбум хүртэлх төгрөгийг зарцуулж, өнгөрсөн хугацаанд нийт 111,9 тэрбум төгрөг зарцуулсан;
- цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт урамшуулал, зээлийн хүүгийн татаасын хүрээнд агаарын чанарын бүсэд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт, ногоон зээл татаасанд 2019-2024 онд нийт 46.1 тэрбум төгрөг, агаарын чанарын бүсэд айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад хийсэн нөлөөллийн арга хэмжээнд нийт 36.1 тэрбум төгрөг, Орчны бохирдлыг бууруулах ажлын албаны үйл ажиллагааны зардалд 2.4 тэрбум төгрөг, нийслэлийн агаарын чанарын бүсэд чиглэсэн төсөл арга хэмжээний зардал 44.6 тэрбум төгрөг, орон нутагт агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийсэн төсөл арга хэмжээний зардал 12.3 тэрбум төгрөг, “Таван толгой түлш” ХХК-д сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, түгээлттэй холбоотой санхүүжилтэд 67.8 тэрбум, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт борлуулалт, хадгалалттай холбоотой санхүүжилтэд 37.2 тэрбум, шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжих Дархан-Уул аймгийн ЗДТГ, Өвөрхангай аймагт 4.3 тэрбум төгрөг, хяналт шалгалтын хүрээнд агаарын чанарын бүсэд түүхий нүүрс оруулахыг хориглох тухай тогтоолын хэрэгжилтийг хангуулах, агаарын чанарын бүсийг дэглэмийг мөрдүүлэх 16.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, зарцуулсан;
- халаалтын зуухыг төвлөрсөн дулаан хангамжид холбосноор, түүхий нүүрсний хэрэглээ 204.6 мянган тонноор, нүүрсхүчлийн хий 547.0 мянган тонноор буурсан. Хэрэглэгчийн шөнийн тарифыг хөнгөлснөөр гэр хорооллын айл өрхүүдийн шөнийн тарифын хөнгөлөлтөд хамруулснаар иргэд цахилгаан халаагуур ашиглах санхүүгийн боломж бүрдсэн.

4.2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр “Утааны асуудал: Зуух, түлшний технологийн шийдлүүд” сэдвээр дөрөв дэх хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал удирдан явууллаа.

Тус хэлэлцүүлэгт нийт 70 иргэн оролцсон болон 28 аж ахуй нэгж байгууллага, иргэдийн төлөөлөл өөрсдийн шийдэл, шинэ санаачилга, бүтээлээ танилцууллаа.

Хэлэлцүүлэгт танилцуулсан мэдээллээс товч танилцуулбал:

- утаа бууруулах технологийн шийдлийг төрөөс сонгохгүй, иргэд өөрсдөө сонгох боломжийг олгох хэрэгтэй. Төрөөс зөвхөн утаа гаргахгүй байх шаардлага тавиад, хөнгөлөлттэй зээл санал болгох шаардлагатай;
- гэр хороололд хэсэгчилсэн болон бие даасан дэд бүтцийн шийдлийг дэмжих дулаан цахилгаан станцууд барих;
- шахмал түлшний түүхий эд болох мидлингийг сольж, үнслэг багатай сайн чанарын нүүрс ашиглах, гэхдээ хагас кокс, хөх нүүрсний үйлдвэрт хөрөнгө зарцуулахаас зайлсхийх;
- цахилгаан халаалт ашиглах;
- нүүрснээс хийн түлш үйлдвэрлэх мега төслийн танилцуулга болон бусад эх үүсвэрээс хийн түлшээр хангах;

- сайн дулаалсан барилгыг нарны энергиэр халаах жишээ;
- модлог био-түлш ашиглах боломж;
- цэвэрлэх байгууламжийн шугамын урсгал, дулааны насос ашиглан дулааны станц барих, нарны дулааны коллектор, дулааны насосоор байшин халаах шийдлүүд;
- дулааны нөөцлүүр цахилгаан халаагуур гэр, байшинд ашиглах талаар;
- хүндийн хүчний цахилгаан станцын технологийг ашиглахад Засгийн газраас буцалтгүй тусламжаар үйлдвэрлэлийн зардлыг гаргаж, өргөн хэмжээнд бодлогоор түгээх боломжийн талаар;
- аэро-гель, будаг, түрхлэг зэрэг орчин үеийн дулаан тусгаарлагч супер материалуудыг ашиглаад, гэр, байшин дулаалах шийдлүүд;
- Улаанбаатар хотод хэд, хэдэн байршилд 150 метр өндөртэй цамхаг байгуулаад, агаарыг сороод, шүүгээд, дээш нь өндөрт гаргаад, нөлөөллийг нь бууруулах шийдлийг Оюутолгойн далд уурхайн босоо амтай харьцуулж хийсэн шийдлийн танилцуулга зэрэг болно.

“АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХҮРЭЭНД УТААНЫ АСУУДЛААРХ БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН, ШИЙДЭЛ” СЭДЭВТ ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЛААР:

2025 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Төрийн ордонд “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдэвт ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2 дахь хэсэгт заасны дагуу ерөнхий хяналтын сонсгол явуулах талаар зар мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 17.30 цаг хүртэл олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сонсголд оролцогчдыг бүртгэлээ.

Сонголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна төрийн бус байгууллагын төлөөлөлт 6, иргэд 94, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл буюу шууд дамжуулж байгаа 2 телевиз нийт 104 оролцогч бүртгүүлснээс төрийн байгууллагын төлөөлөл 64, Төрийн бус байгууллагын болон иргэдийн төлөөлөлд 46 оролцсон болно.

Сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-т “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу хэвлэл мэдээллийн төлөөлөл оролцох эрх нь нээлттэй байгаа учраас МҮОНРТ-ээр шууд дамжууллаа. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хэл яриа сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, тэдний сонсголд оролцох, ажиглах боломжийг хангах зорилгоор өнөөдрийн сонсголыг МҮОНРТ-ээр дохионы хэлмэрчтэйгээр шууд дамжуулсан болно.

Сонсголд дараах дүгнэлтийг танилцуулсан. Үүнд:

- Агаарын бохирдол-хүн амын эрүүл мэнд (Амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх) сэдэвт хэлэлцүүлгийн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.)

- I хэлэлцүүлгийн сэдвийн шинжээчийн дүгнэлтийг Анагаах ухааны доктор, дэд профессор, Орчны эрүүл мэндийн судлаач Б.Сувд;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү.)
- Стандарт, хяналт (зуух түлшний технологи)” сэдэвт хэлэлцүүлгийн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3-аас үзнэ үү.)
- II хэлэлцүүлгийн сэдвийн шинжээчийн дүгнэлтийг Шинжлэх ухааны доктор (ScD)-ын Ж.Нарангэрэл;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 4-өөс үзнэ үү.)
- Эрх зүйн орчин, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, санхүүжилт, зарцуулалт, хариуцлага” сэдэвт хэлэлцүүлгийн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 5-аас үзнэ үү.)
- III хэлэлцүүлгийн сэдвийн шинжээчийн дүгнэлтийг Шинжээч Л.Эрдэнэчулуун Г.Жавхлан;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6-аас үзнэ үү.)
- “Зуух түлшний технологийн шийдлүүд”-ийн талаарх уулзалт, хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-оос үзнэ үү.)

Сонсголд оролцогчдоос илэрхийлсэн санал, мэдээлэл, дүгнэлтийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.4-т заасны дагуу “оролцогчийн санал, мэдээлэл, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байх” гэж заасны дагуу хоёр өдрийн сонсголд оролцогчдоос нийт 81 оролцогч 3 минутад багтаан саналаа илэрхийлсэн.

Оролцогчдын гаргасан санал, мэдээлэл, дүгнэлтийг тоймлон авч үзвэл:

- Цаашдаа үйл ажиллагаагаа сайжруулъя, агаарын бохирдлыг байхгүй болгоё, дараа өвөл гэхэд арай цэвэрхэн агаараар амьсгалъя гэж бодож байгаа бол өмнө нь гаргасан алдаагаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Эрчим хүчний салбар, цаг уур орчны шинжилгээний салбар, байгаль орчны салбар, эрүүл мэндийн салбар, боловсрол бүх салбаруудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаа талаар;

- Монголчууд бол нүүрсээ түлж байсан, нүүрсээ түлж байх үед хааяа л ганц нэг хүн угаартсан тухай, нас барсан тухай ярьдаг байсан. Жилдээ ер нь 1, 2 хүн л угаартаж нас бардаг байсан. Одоо бол шахмал түлш түлснээс хойш зуу зуугаараа угаартаж нас бардаг болсон, зуу зуугаар нь оршуулдаг болсон. Тэгээд энэ түлшээ гадаадад, Америкт, Орост, Хятадад шинжлүүлээд маш сайн үр дүн үзүүлсэн гэж яриад байх юм. Монголын ард түмэн энэ түлшний үр дүнг амь насаараа төлчхөөд байж байна. Иймд сайжруулсан шахмал түлшийг цаашид түлэх эсэх болон угаартаж нас барсан иргэдийн тоо мэдээлэл зөрүүтэй байгаа талаар,

- Агаар орчны бохирдлыг бууруулахдаа салбарын зардалд суурилсан, эдийн засгийн механизмыг өнөөдөр хүртэл хэрэгжүүлж ирсэн нь ямар ч үр дүн гардаггүй гэдгийг нотолчихсон. Харин иргэдийн орлогод суурилсан, иргэдийн олон талын оролцоотой хамтын менежментэд суурилсан бодлого баримталж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлбэл амжилтад хүрэх боломжтой талаар,

- Тэтгэврийг 6 хувь нэмж, эрчим хүчнийхээ хураамжийг 89 хувь нэмлээ. Ийм байхад яаж ард иргэдийг яндангаа буулга, халаалтаа дэвшилтэт технологиор, техникээр шийд гэж хэлж чадаж байгаа юм бэ. Гэр хороолол, орон сууцад яг энэ зардлыг чинь төлөөд, иргэдийн өнөөдрийн бодит орлого нь тав тухтай амьдрах, тайван амьдрах ийм нөхцөлийг нь хангахгүй болж байгаа талаар,

- Өнөөдөр утааг өвлийн хүйтэнд бид нарт харагдаж байгаа учраас агаарын бохирдол гэж ярьж байгаа. Урин дулаан хавар, зун, намрын улирал эхлээд хөрс, усны бохирдол үүнээс илүү аймшигтай үр дагаврыг дагуулж, орчныг бохирдуулагч, хүний эрүүл мэндийг бохирдуулагч үндсэн эх үүсвэр болчихсон байгаа. Агаарын бохирдлын асуудлыг ярьснаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалахгүй талаар,

- Шийдвэр гаргаж байгаа хүмүүс нь бие биеийнхээ бизнесийг дэмжиж олон жил явсаар байгаад олон хүний амь нас үрэгдсэн асуудал болж байгаа. Одоо ард иргэдээс төлөөлөл оролцуулаад хяналт тавьдаг механизмаг бүрдүүлж, шийдээд, гарц гаргалгаагаа яриад, хариуцлага тооцдог болох талаар,

- “Ухаалаг барилга” гээд цэвэр эрчим хүчний хэрэглээтэй, эрчим хүчний хэмнэлттэй, хог хаягдлын тэг менежменттэй, ахуйн бохир усыг 100 хувь цэвэршүүлсэн, үйлдвэрлэсэн ухаалаг барилгыг монгол эрдэмтэд, монгол барилгачид санаачлаад технологи, инновацын шийдлийг нь гаргаад 2014 онд Налайх дүүрэг рүү барилгачдаа аваад бид нар энэ утаанаас, түгжрэлээс гарч шилжин суурьшъя гэсэн хөдөлгөөн өрнүүлээд явсан юм. Гэтэл 2014 оноос хойш одоо хүртэл нэг ч ажил байхгүй, нэг ч дэмжлэг байхгүй талаар,

- Бидний хэрэглэж байгаа шахмал түлшнийхээ чанарыг урд, хойд 2 хөршийнхөө стандартын түвшинд хүргэх шаардлагатай юм байна. Яагаад гэвэл одоо хэрэглэж байгаа коксжих нүүрсний завсрын бүтээгдэхүүн бол хүхрийн агууламж өндөртэй, 70-80 хувь нь сульфид их агуулж байгаа, мөн үнслэг өндөртэй 29 хувь, энэ агуулгууд нь бүгдээрээ чанарын хувьд 3 дахин муу түлш байна. Тийм учраас эдгээр үнс, хүхэр хоёртой холбогдуулаад өнөөдрийн угаарын хий, хорт утаа ялгарч байгаа асуудал энэ түлштэй холбоотой. Тийм учраас түлшний стандартыг сайжруулах талаар,

- Улаанбаатар хотыг хамгийн их орчны бохирдлыг үүсгэж байгаа 3 зүйл байна. Улаанчулуутын хогийн цэг салхины аман дээрээ байна. Нарангийн энгэр оршуулгын төв нь салхины аман дээр байна. Гэр хороолол салхиныхаа аман дээр оччихсон манай Монгол чинь өөрөө салхи баруун хойноос салхилдаг тэгээд л нэг салхи гарахаар л хотын иргэд бид баярлах юм. Тэгээд баярлахдаа нас барсан иргэдийнхээ цогцсыг амьсгалж байна. Хогийн машин Улаан чулуутын хогийн цэг дээр аваачаад хогоо асгачхаад гарахад ямар ч тийм ариутгал хийж цэвэрлэгээ хийдэггүй. Тэнд асар их хэмжээний нян хогийн машинд хуримтлагдчихсан байгаа. Улаанбаатар хотын төвөөр бид нянгаар амьсгалдаг талаар,

- Нүүрсээ түлээд цахилгаан эрчим гаргаж байгаа Монголоос өөр улс дэлхий дээр бараг байхгүй байх. Бүгд л цөмийн станц. Бид яагаад энэ цөмийн станцаас айж

зугтаагаад байгаа юм. Цөмийн станцаа барь л даа. Нүүрс түлээд л энэ чинь хоцорчихсон технологи. Тийм учраас цөмийн станцаа барих хэрэгтэй, эрдэмтдийнхээ дуу хоолойг сонсмоор байгаа талаар,

- 2017-2025 онуудад хэрэгжсэн үндэсний хөтөлбөрүүдийн төлөвлөсөн ажил нь шалгуур үзүүлэлтээсээ тэс ондоо, зөрчихсөн. Бодлогын бичиг баримт боловсруулалт, уялдаа холбоо хангалтгүй байгаа, түүнийгээ хэрэгжүүлсэн дүр эсгээд явдаг. Мэргэжлийн бодлого боловсруулагчдыг оролцуулсан байдлаар төсвийн бодлогоо боловсруулаад, төлөвлөгөөгөө гаргаад хэрэгжүүлэх талаар,

- 2009-2025 он хүртэл 163 хүн нас барсан гэсэн шинжээчийн дүгнэлтэд дурдсан тоо мэдээлэл зөрүүтэй байна. Түрүү жил шүүхийн шинжилгээний статистикийн бүх дүн шинжилгээгээр 2017-2025 оны 1 сарын 1-ийг хүртэл байдлаар Монгол Улсад угаарын хийн хордлогоор 794 хүн нас барсан байна. 2017 онд 74 хүн нас барсан. Шахмал түлш хэрэглэснээс хойш 2018 оноос хойш 720 хүн нас барсан байна. Төрийн байгууллагын тоо мэдээлэл зөрүүтэй байгаа талаар болон бодит статистик мэдээллийг нийтэд ил болгох асуудлын талаар,

- Нийслэлийн төсвөөс нийслэлчүүдийн эрүүл мэндийн төлөө агаар орчны бохирдлыг бууруулахад яг хэдэн төгрөг юунд зарцуулахаар төсөвлөсөн болон Агаар орчны бохирдолтой тэмцэх чиглэлээр зарцуулсан зардлын талаар,

- Агаарын бохирдол, утааны асуудлаар иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хяналт шалгалтыг явуулах талаар,

- Сонсгол зохион байгуулагдсаны дараа бодит дүн гаргахын тулд сонсголын зохион байгуулж буй ажлын хэсгийн гишүүд нөхцөл байдлыг бодитой тодорхойлж, төрийн бодлого шийдвэрийн алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрөх, түүнчлэн агаарын бохирдлын асуудлыг нэн тэргүүний асуудал хэмээн үзэж шийдвэрлэх улс төрийн хүсэл зориг үүрэг хариуцлага бүрэн ухамсарлаж жилийн дөрвөн улиралд орхигдолгүйгээр асуудалд хандах талаар,

- Утаа бууруулах шийдэл болгож нарны эрчим хүчийг дулааны эрчим хүч болгон гэр байшинг тосгон халаах шийдлийг санал болгосон. Нэг шийдэл нь нарны хавтан, дулаан, нөөцлүүр, ухаалаг удирдлага систем. Энэ нь нэг айлын буюу гэр байшинг халаана. 2 дахь нь нарны хавтан, дулаан, нөөцлүүр, дулааны насос, ухаалаг удирдлагын систем гэсэн. Энэ нь болохоор тосгон болон олон давхар байшин халаах юм. Эдгээр халаалтын системийн тооцоо судалгаа хийгдэж туршигдсан оюуны өмчийн байгууллагаас патентлагдсан бүтээлүүд учир иргэдийн ийм шинэ санал, санаачилгыг төрөөс хөрөнгө оруулалтаар дэмжих талаар,

- Утаа ярьж байгаа боловч утааг бүрдүүлж байгаа бүрэлдэхүүн хэсэг дотор нь байгаа шахмал түлшний тухай асуудлыг ярьж байна. Гэтэл нөгөө талд нь орхигдуулаад байгаа зүйл болох чанаргүй, муу, стандартын шаардлага хангахгүй байгаа дизель түлш бензиний асуудлыг давхар ярьж холбогдох байгууллагууд нь судалгаа шинжилгээгээ хийх хэрэгтэй байгаа талаар,

- Эрүүгийн хууль дээр 2017 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр төрийн өндөр албан хаагчийн үйлдсэн болон эс үйлдэхгүйгээр үйлдсэн гэмт хэрэг улсад болон нийгэмд учруулсан их хэмжээний хохирол дээр төрийн албан хаагч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй гэсэн утгатай. Хариуцлага хүлээх заалтыг нь хүчингүй болгосныг буцааж сэргээх талаар,

- Агаарын бохирдол, утаанаас болж амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүмүүст нөхөн олговор олгох асуудлыг яаралтай шийдэх чиглэлээр хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар,

- Улсын Их Хурлаас Хянан шалгах түр хороо байгуулж ажиллах, хяналт шалгалтын механизмыг сэргээж, нэгдсэн хяналт, стандарт хяналт, эргэх холбоо, хариуцлагын асуудлууд дээр анхаарах шаардлагатай байгаа зэрэг асуудлыг тус тус сонголд ороцлогчдийн зүгээс хэллээ.

Дүгнэлт, танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариулт:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.5-д *“гишүүн оролцогчоос асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно.”* гэж заасны дагуу сонголд оролцсон Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Б.Бейсен, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Ж.Золжаргал, С.Замира, Б.Жаргалан, М.Мандхай, Л.Мөнхбаясгалан, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, Д.Рэгдэл, С.Эрдэнэболд, Д.Энхтуяа нарын гишүүд асуулт асууж, холбогдох албан тушаалтнаас хариулт авлаа.

Асуулттай холбогдуулан Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнаас гадна сонголд оролцогчид хариулт өгсөн болно.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга С.Одонтуяа, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилгын материалын хэлтсийн дарга Д.Батзориг, ШУА-ын Хими, химийн технологийн хүрээлэнгийн Нүүрсний хими техникийн лабораторийн эрхлэгч Г.Шийрав, мөн хүрээлэнгийн Багажит шинжилгээний лабораторийн эрхлэгч Ж.Нарангэрэл, Стандарт, хэмжил зүйн газрын ахлах мэргэжилтэн Г.Батзориг, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, Эрчим хүчний зохицуулах хороо зохицуулагч Л.Дашмягмаржав, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат зэрэг албан тушаалтнуудаас гадна “Тавантолгой түлш” ХХК, “Энержи ресурс” ХХК-ийн зэрэг аж ахуйн нэгжийн албан тушаалтнуудаас хариулт өглөө.

Асуулт асуусан Улсын Их Хурлын гишүүдийн асуултыг тоймлон авч үзлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ төрийн албанд хариуцлагагүйн зуд нүүрлэж буйг дурдаад агаарын бохирдлыг бууруулах асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын үйл ажиллагааг өргөтгөн үргэлжлүүлж, Хянан шалгах түр хороо байгуулах, яндангаа буулгасан айлуудад урамшуулал олгох, дулаалгын шинэ технологи нэвтрүүлж буй аж ахуйн нэгжүүдийн дунд чөлөөт өрсөлдөөн бий болгох шаардлагатай гэв. Мөн тэрбээр агаарын бохирдлыг бууруулах асуудлыг байгаль орчны салбар бус эрчим хүчний яаманд хариуцуулж, хариуцлагыг нь тооцдог байх нь зүйтэй гэж байлаа.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара маргаашийн сонголд агаарын бохирдлыг бууруулахад шийдвэр гаргасан, гаргаж буй холбогдох албан тушаалтнуудыг бүгдийг дуудаж оролцуулах, Улсын Их Хурлын гишүүн С.Замира сайжруулсан шахмал түлшний үйлдвэр, нүүрс түлэхийг цаашид зогсоох, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун агаарын бохирдлын улмаас иргэдийн амь нас, эрүүл мэнд хохирч, хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдээс уучлал хүсэхийг мэдэгдээд дулаалгын технологид нэгдсэн стандартыг яаралтай баталж, хэрэгжүүлэх нь чухал гэж байлаа. Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, агаарын бохирдлыг бууруулж чадаагүй алдаагаа салбарын яамдууд хүлээн зөвшөөрч байж, гарц шийдлээ амархан олох, улмаар асуудлыг хариуцлагажуулж эзэнжүүлэх нь чухал гэсэн бол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа 2017 онд байгуулагдсан “Тавантолгой” түлш ХХК-ийн удирдах албан тушаалтнуудад хариуцлага тооцохоос сонсголын үр дүн эхэлнэ гэж байлаа. Мөн Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа асуудлыг шийдвэрлэх гол байгууллага Улсын Их Хурал тул эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Хянан шалгах түр хороо байгуулах, хяналт тавих, төсөв батлах эрх мэдлийнхээ хүрээнд томоохон шинэчлэл хийх нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлэв.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог Шадар сайдад хариуцуулж салбар хоорондын уялдааг хангах, сонсголын үр дүнд төрийн бодлого нэгдмэл гарах ёстой. Түүнчлэн түлш, зуухыг сайжруулах, дулаалгын технологийг нэвтрүүлэх, хэрэглэгчийг төлөвшүүлэх гэсэн дөрвөн асуудлыг зэрэг шийдвэрлэвэл утааг бодитойгоор багасгана гэв. Харин Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал төрөөр дамжуулж технологийн туршилт хийдэг энэ хандлагыг халах цаг болсныг онцгойлон анхааруулаад технологи, инновац хөгжүүлдэг тогтолцоогоо ажиллуулж, эрх зүйн орчныг нь сайжруулах нь чухал гэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар агаар, утааны бохирдлыг бууруулахад чиглэсэн сонсголыг өргөжүүлж Улсын Их Хурлаас энэ чиглэлээр түр хороо байгуулж үр дүнд хүртэл иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтайгаа хамтран ажиллах шаардлагатай гэсэн бол Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ сонсголоор асуудлыг хязгаарлалгүй Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо цаашид утаа, агаарын бохирдлыг бууруулах дэд хороог байгуулж, асуудалд хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, утаа бууруулах шийдлийг гаргаж буй аж ахуйн нэгжүүд, яндангаа буулгасан айл өрхүүдэд чиглэсэн төрийн дэмжлэг үзүүлэх, агаарын чанартай холбоотой нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн мэдээллийг хүргэх, хариуцлага тооцох зэрэг асуудлыг сонсгол зохион байгуулсан ажлын хэсгийн дүгнэлтэд тодорхой тусгах саналыг хэлсэн. Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Улсын Их Хурал, Засгийн газар, нийслэлийн түвшинд шийдвэрлэх хамгийн тулгамдсан асуудал болох утааг бууруулахад чиглэж, ажиллахыг уриалаад утаанаас салах гарц нь эрчим хүч гэдгийг хүлээн зөвшөөрч, эх үүсвэрээ нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлэв. Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаж, шалгуур үзүүлэлтээ тодорхой болгож, Монгол хүний амь нас, эрүүл мэндэд ноцтойгоор аюул учруулж болзошгүй асуудлын ангиллыг тогтоож, тухайлсан хөрөнгө төсөвлөх хэрэгтэй гэж байлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1.6-д “*гишүүн оролцогчоос асуулт асууж, хариулт авч дууссаны дараа 5 минутад багтаан үг хэлж болно*” гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Ж.Золжаргал,, С.Замира, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, С.Одонтуяа, О.Саранчулуун, Д.Энхтуяа нарын нийт 9 гишүүн үг хэлэв.

“Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” ерөнхий хяналтын сонсголыг хааж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хэлсэн үгэндээ, Ардчилсан парламент нь иргэдээ сонсдог төр болоход чиглэж, Үндсэн хуульд томоохон өөрчлөлт оруулж, 126 гишүүнтэй танхимыг бүрдүүлж, бодлогын асуудлаа танхимдаа ярьдаг болохыг зорьсон. Үүний илрэл нь Монгол Улсын тулгамдсан асуудлаар сонсгол явуулж, иргэдээ сонсдог болж буй энэ үйл явц гэж ойлгож болно. Эмч хүний хувьд хэлэхэд эл сонсголоор утаа эрүүл мэндэд асар их муу нөлөөтэй байгааг монгол эрдэмтдийн дэлхий даяар хэвлэгддэг сэтгүүлд хэвлэсэн мэдээллийг олон нийтэд хүргэж, олон шинжээчдийн нотлох баримтаар ил гаргасан гэдгийг дурдаад өнгөрсөн хугацаанд гарсан нэг дэвшил нь түүхий нүүрсээ түлэхээ зогсоосон. Түүхий нүүрсээ түлсээр байсан бол хорт хавдрууд, нярай, ургийн эндэгдлүүд зогсохгүй байсныг онцлов.

Ерөнхий хяналтын сонсголын нэгдсэн санал, дүгнэлт:

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 10 дугаар тогтоолоор “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвийн хүрээнд ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар 2025 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулж, сонсголд Улсын Их Хурлын гишүүд болон оролцогчдоос гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн дараах байдлаар танилцуулж байна:

1. Сайжруулсан түлшний хэрэглээтэй холбоотой хүн амын эрүүл мэнд, амь насанд угаартах аюул учирсаар байх тул угаарын хий мэдрэгчийг айл бүхэнд байршуулах, тогтмол ажиллагааг хянах, угаарын хийн мэдрэгч ажилласан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах боломжтой тогтолцоог нэвтрүүлж, “Таван толгой” түлш ХХК, Нийслэлийн засаг даргын тамгын газраас айл бүрийн эрсдэлийг үнэлж, арилгах;
2. Агаарын бохирдлын талаар мэдээллийг өдөр бүр тогтмол иргэдэд мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, (МҮОНРТ-ийн цаг агаарын мэдээний хамт, Улаанбаатар, орон нутгийн агаарын бохирдлын талаар мэдээлэх гэх мэт) мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
3. Эрүүл мэндийн яамны зүгээс агаарын бохирдолд өндөр эрсдэлтэй, эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэнд, угаартаж амь насаа алдсан нийт хүн амын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлээс сэргийлэх, хамгаалах ажлыг нотолгоонд тулгуурлан эрчимжүүлэх төлөвлөгөөг боловсруулан зорилтот хүн амд хүрч ажиллах, эмнэлгийн бэлэн байдлыг ханган ажиллах;
4. Угаартаж амь насаа алдсан нийт хүн амын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хохирол барагдуулах шаардлагатай арга хэмжээ авах;

5. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо цаашид утаа, агаарын бохирдлыг бууруулах дэд хороог байгуулж, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, хянан шалгах эрх бүхий байгууллагын мэдээллийг тогтмол сонсох; холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх;
6. Хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гадаад, дотоод орчны агаарын чанарын болон нүүрсний стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг асуудал хариуцсан холбогдох яамд нэн даруй батлуулан хэрэгжүүлэх;
7. Агаарын бохирдолд өндөр эрсдэлтэй бүсийг тодорхойлж, тухайн бүсэд байрлах сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээг орон нутгийн төсвөөр шийдвэрлэж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;
8. Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн хямд эх үүсвэр, хөшүүрэг бий болгох замаар янданг буулгах;
9. Агаарын бохирдлын эсрэг авч буй нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхтэй зэрэгцэн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг хамтад нь боловсруулж, иргэд олон нийт, Иргэний нийгмийн байгууллага, Төрийн бус байгууллагуудын үр дүнтэй оролцоог хангаж ажиллах;
10. Цаашид нийслэлийг хатуу түлшний хэрэглээнээс гаргаж хийн болон бусад төрлийн түлшний хэрэглээнд нэвтрүүлэхдээ нэгдсэн стандарт бүхий шаардлага хангасан түлшийг иргэд өөрсдөө сонгох эрхийг хангаж, ахуйн орчин нөхцөлд нь эрсдэлийн болон өртөг үр ашгийн үнэлгээг хийсэн байхад анхаарах;
11. Гэр болон барилга байгууламжийн дулаалгын нэгдсэн стандарт боловсруулан батлуулж, дулаалгын шинэ технологи нэвтрүүлж буй аж ахуйн нэгжүүдийн дунд чөлөөт өрсөлдөөн бий болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээг салбарын яамны зүгээс авч хэрэгжүүлэн мөрдүүлэх;
12. Орон нутаг бүр агаарын тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлж агаарын бохирдлыг хэмжих тоног төхөөрөмжөөр яаралтай хангах, бохирдлыг бууруулах, хүн амыг агаарын бохирдлоос хамгаалах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, шаардлагатай төсвийг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх;
13. Салбарын яамны зүгээс орон нутагт агаар бохирдуулагч бүрийг хэмжих чадавхыг бий болгож, хатуу түлшний хэрэглээг халах;

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

